



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/199

Номгон

“Үзэсгэлэнт Баянхонгор-2” төсөл хэрэгжүүлэх
тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.1.”а”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” 2/8 дугаар тогтоолын хавсралтын 81 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн хүрээнд “ҮЗЭСГЭЛЭНТ БАЯНХОНГОР-2” төслийг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан хамтран зохион байгуулсугай.

2.“Үзэсгэлэнт Баянхонгор-2” төслийн үйл ажиллагаанд шаардагдах 9.980.000 (Есөн сая есөн зуун наян мянган) төгрөгийг орон нутгийн ангилагдаагүй зардлын төсвөөс зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.“Үзэсгэлэнт Баянхонгор-2” төслийн хүрээнд хийгдэх ажлуудыг чанартай гүйцэтгэж, холбогдох баримт материалыг бүрдүүлэх, удирдлага, арга зүйгээр хангаж, хийгдсэн ажлуудын тайлан, материалыг төрийн архивт 2021 оны 09 дүгээр сарын 30-ны дотор шилжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг), сумынхаа холбогдох түүх соёл, байгалийн үзэсгэлэнт газар, зан заншлыг сурталчлан танилцуулж мэдээллээр ханган дэмжиж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН

1210495